

## ҮНЭЛЭМЖИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТЫГ ТОДОРХОЙЛОХ АСУУДАЛД

*Түлхүүр үг: үнэлэмж, үнэлэгч субъект, үнэлгээ, үнэлэгдэгч объект, үнэлэмжийн тодорхойлолт.*

Соёлын онолын хувьд үнэлэмж бол суурь ойлголтын нэг мөн. Тийм ч учраас өнөөгийн ертөнцөд үнэлэмжийн асуудлыг мэдлэгийн нэн өргөн хүрээнд, ялангуяа хүмүүнлэгийн чиглэлийн олон салбарт идэвхитэй шинжлэн судлаж, сургалтанд нэвтрүүлсээр байгаа билээ. Гэтэл гадаад, дотоодод хэвлэн нийтлэгдсэн судалгааны болоод сургалтын зориулалттай цөөнгүй тооны бүтээлийг харж байхад уг сэдвийг харьцангуй "олон өнгө аястай" болгож, зарим тохиолдолд "хүсэл эрмэлзлэлийн" шинжтэй авч үзэж, түүний үзэл баримтлалын томъёолол нь ойлгомжгүй, илэрхийлсэн санаанд нь логик зөрчилтэй, зүйл мэр сэр ажиглагдаж байна. Энэ нь юуны түрүүнд манай сургалтын практикт зохих бэрхшээлийг учруулж болох юм. Тэгэхлээр бид энэ асуудлаар өөрсдийн санаа бодлыг мэргэн олонтойгоо хуваалцах зорилго өвөрлөсөн болой.

Германы философич Рудольф Херман Лотце (1817-1881) үнэлэмжийн тухай онолыг философи эргэцүүллийн талбар болгох эх суурийг тавьсан гэж тооцогддог. Энд түүний "Практик философийн үндэслэгээнүүд", "Бичил орчин" хэмээх бүтээлүүд нь чухал үүрэг гүйцэтгэжээ. Цаашид Ф.Ницше: ахуй бол объектив бодит байдал биш, харин үнэлэмж мөн гэснээрээ онтологийг аксиологид хамааруулж, М.Хайдеггерийн нэгэнт тэмдэглэсэнчлэнгээр соёлын онолын хүрээнд үнэлэмж өөрийн байр сууриа эзлэхэд түүний философи шийдвэрлэх хувь нэмэрийг оруулсан байдаг.

Харин үнэлэмжийн тухай онолыг философи сургаал болгоход гол үүрэг гүйцэтгэсэн сэтгэгчид бол шинэ кантч философийн Бадены сургуулийн төлөөлөгч В.Виндельбанд (1848-1915), Г.Риккерт (1863-1936) нар болно /2. 14,16/. Тэд байгалийн шинжлэх ухааны асуудлыг үнэлэмжийн объект болгоогүй, учир нь, тэдгээрт үнэлэмжийн утга үйлчилдэггүй ажээ. Тэрээр

ерөнхийн тухай бус, харин тусгаар шинжтэй аргыг хэрэглэх үндсэн дээр туршлагын онцгой хүрээ болх соёлыг судлагдахуунаа болгосон байна. Тиймээс философи нь шинэ кантч философийн Бадены сургуулийн эдгээр төлөөлөгчдийн үзсэнээр нийтэд илүү хүртээмжтэй ойлгогдох үнэлэмжийн тухай сургаал болж байгаа юм.

Гэтэл энэ философийн Марбургийн сургуулийн төлөөлөгчид, тухайлбал, Г.Коген (1842-1918) үнэлэмжийг бодгаль субъектийн биш, харин трансценденталь субъектийн "цэвэр хүсэл эрмэлзлэл" төрүүлж байдаг гэж, В.Вундт болон зарим төлөөлөгчид хүсэл эрмэлзлэлийн хүчин зүйлийн үүднээс үнэлэмжийг үндэслэдэг Бадены сургуулийн баримтлалд мэдрэмжийн хүчин зүйлийг сөргүүлэн тавьсан нь буй. Бас дээрхи субъективист үзлийг үл хэрэгсэн, мэдрэмж төдийгүй үнэлэмж объектив шинжтэй гэж үздэг төлөөлөгчид тэдэнтэй зэрэгцэн гарч ирсэн нь Австрийн философич Ф.Брентано (1838-1917), А. фон Мейнонг (1853-1920), Германы социологич М.Шелер (1874-1928) нар байлаа / 9. 309-314/.

XX зуунд үнэлэмжийн онол философийн нэн чухаг салбар болон хөгжиж ирсэн нь аж үйлдвэржсэний дараахи нийгэм, постструктурализм, постмодернизм, посткоммунист орнууд гэх зэргээр "үнэлэмжүүдийг шинэчлэн ухаарах" үйл явцаар илэрч байна. Өнөөдөр үнэлэмжийн асуудал философи, соёл судлал, социологи, хүн судлал, сэтгэл судлал болон хүмүүнлэгийн олон ухаануудад хангалттай гүнзгий тусгагджээ (Э.Дюркгейм, Р.Перри, Ж.Дьюки, О.Шпенглер, А.Тойнби, П.Сорокин, К.И.Льюис, Т.Парсонс, В.Келер гэх мэт).

Эдгээрээс үзэхэд Өрнөдийн соёлын хүн судлалд онолын хоёр туйл байна гэж үзэж болох юм. Энд: 1. Янз бүрийн нийгмийн үнэлэмжийн бүтцийн объектив шинжилгээний боломжийг үгүйсгэж, үнэлэмжийн тогтолцоог харьцангуй гэж үзэх релятивист онол; 2. Үнэлэмжийн бүтцийг объектив шинжлэх ухааны байр сууринаас судлах бололцоог нотолдог антирелятивист позитивизм зэргийг дурдаж болно /6. 124 /.

Бид энэхүү өгүүллийн багахан хүрээ хэмжээнд багтаан уг сэдэвт холбогдох сэтгэгч, судлаач болгоныг татан оруулж, тэдний үзэл санаа, онол баримтлалд үнэлэлт өгөх зорилго тавиагүй ч, зарим нэг сэтгэгчийн өгсөн тодорхойлолт, илэрхийллийг толилуулья.

Орос-америкийн философич социологич П.А.Сорокин чухам л үнэлэмж аливаа соёлын суурь болдог гээд ямар үнэлэмж давамгайлж буйгаас

хамааруулан соёлын тогтолцоог тэрээр: 1. Идеациональ (эзэн тэнгэр, сүсэг бишрэл гэх мэт үнэлэмжтэй); 2. Мэдрэхүйн (шинжлэх ухааны нээлт, статистик мэдээ, технологийн бүтээл гэх мэтсийн үнэлэмжтэй); 3. Идеалист (дээрхи хоёрын хоорондох, дундаж чанарын үнэлэмж бүхий) гурван хэв маягт хувааж үзсэн байдаг /6. 125/.

Америкийн социологич, соёлын онолч Т. Парсонс "Үнэлэмж бол зан үйлийн альтернативыг сонгоход нөлөөлөх, хүсэж буй зүйлийн тухай төсөөлөл юм" /6. 124/ гэж тэмдэглэжээ. Тэгвэл бидний үзэж байгаагаар соёл бол зөвхөн эерэг үнэлэмжүүдээс бүрддэггүй, бас сөрөг хэм хэмжээлэг санаанууд чухал байр суурь эзэлдэг тул дээрх тодорхойлолтонд "үл хүсэх" тал нь орхигдсон мэт санагдана.

Харин АНУ-гийн судлаач К. Клакхон, Ф. Стробек нар үнэлэмжийг "...хүн төрөлхтний нийтлэг асуудлыг шийдвэрлэх явцад хүний сэтгэлгээ болон үйл ажиллагааны янз бүрийн сэдэлд чиглэл, цэгц авцалдаатай байдлыг олгох нарийн нийлмэл бөгөөд тодорхой утгаар бүлэглэгдсэн зарчмууд мөн" гэж тодорхойлсон байх юм /13. 157/. Бас л сонирхолтой тодорхойлолт. Энэ мэтчилэн хангалттай олныг хэлж болно.

Америкийн улс төрч Д. Девайн АНУ-ын 28 томоохон нийгэм судлаачдын дунд судалгаа явуулж, тэдний төсөөллийг харьцуулан үзэхэд **консенсус** илэрсэн байна. Тэднээс 23 нь хувийн өмчийг, 22 нь тэгш эрхийг, 20 нь эрх чөлөөг үндсэн үнэлэмж гэсэн байна /6. 131/. Эндээс ч бас нэг юм харагдаж байгаа байх. Юу гэвэл нэг талаас ер нь энэ ойлголтын цаана юуг ойлговол зохилтой болох, нөгөө талаас ардчилал өндөр хөгжсөн улс оронд ямар үнэлэмжийг илүү эрхэмлэн үздэгийг олж харж болох болов уу гэж бодож байна.

"Соёл" хэмээх ойлголтонд нэн шадар холбогдох 50 орчим ойлголтыг онцолж үзэхэд түүний гол ойлголт болох үнэлэмжтэй илүү ойр дөт ойлголтын тоонд хэм хэмжээ, чин эрмэлзлэл, хэрэгцээ, ашиг сонирхол, хүсэл, сэдэл, утга, хүсэл зориг, уламжлал, заншил, ёслол, зуршил гэх зэрэг ойлголт зүй ёсоор орж байгаа нь ажиглагдсан. Гэхдээ соёлын чухал хэсэг болох үнэлэмж нь сайн муу, сайхан муухай, хэрэгтэй хэрэггүй, хортой хоргүй, ашигтай ашиггүйг хүнд ялгаж өгдөгөөрөө онцлог болно.

Үнэлэмжийн тухай бодитой ойлголт авахын тулд түүнийг мөсөн уултай зүйрлэж үзэж болох юм. Учир нь үнэлэмж нь өөрийн уг чанараар ихээхэн

субъектив чанартай бөгөөд үнэндээ энэ нь хүний оюуны практик үйл ажиллагаа болно. Өөрөөр хэлбэл хүний дотоод ертөнц дэх үйл мөн. Тэгэхлээр түүнийг мөсөн уулын усны мандал доорхи бидэнд шууд харагдаж, мэдрэгдэхгүй байгаа хэсэг гэж зүйрлэж болно. Харин усны мандал дээр ил харагдах хэсэг бол бидэнд шууд мэдрэгдэх, хүний гадаад илрэл, зан үйл, хэлэхүйн (вербаль) ба хэлэхүйн бус (вербаль бус) аргаар өөрийгөө илэрхийлэхүй нь болой. Энэ бол харин хүний бие эрхтэн, нүүр царай, дуу хоолойгоор дамжин илрэх материаллаг практик үйл ажиллагаа болж байгаа юм.

Үнэлэмж соёлын бусад үзэгдлүүдээс онцлогдох нэг ялгаа нь түүний биологи улбаатай чанар гэж үзэж болно. Цөөн жишээг энд татъя. Муур хулганыг барьж идээд түүний ходоодыг үлдээсэн байдаг. Энэ нь түүнд хулганын махнаас ялгавартай хандсаных. Нохойд зөөлөн хоол өгөөд байхад сүүлдээ ясыг голоод байдаг болчихдог, мал тавьж өгсөн өвсний заримыг нь шилж идчихээд, нэг хэсгийг нь идэхгүй гишгэчээд байх. Зэрлэг ан амьтан өөрт аюултай дайсан, аюулгүй амьтаныг ялгаад байдаг. Энэ бүгдээс үзэхэд адуусан амьтанд дор хаяж дуртай дургүйг, таашаах таашаагдахгүйг ялгаж хандах чадвар бий ажээ. Үнэлэмжийг авч үздэг натуралист онолын Р.Перри, Д.Паркер, Ф.Теннант зэрэг төлөөлөгчид түүнийг биологийн төрөлх хэрэгцээний илрэл буюу байгалийн хууль бүхэлдээ илэрч буй нь юм хэмээснийг энэ дашрамд дурдъя. Тэгэхдээ бид үнэлэмжийг зөвхөн биологийн хүрээнд авч үзэж, амьтан гадаад орчинтойгоо харьцах арга болсон инстинкт гэж хараахан үзэхгүй байгаа юм шүү.

Орос хэл дээр хэвлэгдсэн хэд хэдэн сурах бичиг, гарын авлагыг сөхөж үзвэл зарим нэг шүүмжлэлтэй хандахаар зүйл тааралдаж байсныг дурдах нь зүйтэй мэт. Тухайлбал, А.А.Оганесян зохиогчтой 2000 онд Москвад хэвлэгдсэн "Соёл судлал. Лекцийн конспект" номонд "Оюуны соёлд 4 үндсэн хэсэг байна" гэсний 3-т "үнэлгээ-мэдлэг бол хүний үнэлэмжийн ертөнц мөн. Үнэлэмжүүд өөрсдөө ертөнцөд объектив (биднээс хамаарахгүй) оршино, харин тэдгээрийн үнэлгээ субъектив (биднээс хамааран) байх юм" гэжээ. Цааш нь үнэлэмжийн үндсэн төрлүүд гэдэгт дараах хэдэн зүйлийг жагсаасан байна. Үүнд:

- биет юмслаг;
- хүний үнэлэмж бүхий юм, үйл явц өөрсдөө;

- хэм хэмжээ, заншил, уламжлал;
- чин эрмэлзлэл;
- мэдлэг /5. 10/ зэргийг багтаажээ.

Эдгээрээс харахад оюуны соёл гэдэгтээ үнэлэмжийг оруулсан мөртлөө үнэлэмжийн үндсэн төрлүүдэд материаллаг хийгээд санаалаг зүйлсийг хоёуланг оруулсан нь төдийлөн зохимжтой бус санагдаж байгаа юм.

Бас Н.Г.Богдасарян редакцитайгаар 2001 онд Москвад хэвлэгдсэн "Соёл судлал" сурах бичигт "Үнэлэмж нь зан үйлийн үлгэр болон стандартыг өгч, зан үйлийн боломжит сонголт нөлөө үзүүлэх, тодорхой соёлд хэвшин буй болсон, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ юм" /6. 123/ гэсэн тодорхойлолт өгчээ. Уг тодорхойлолтын үндсэн санаанууд ерөнхийдөө бидэнд таалагдаж байгаа ч "нийтээр хүлээн зөвшөөрсөн" гэсэн санаа нь маргаантай байж болох юм. Учир юун гэвэл үнэлэмж болгоныг нийгмийн бүхий л субъектийн төвшинд яг адилхан хүлээн зөвшөөрөх боломжгүй биз. Нөгөө талаар субъектийн үнэлэмжид хүний нас, хүйс, мэргэжил, боловсрол, амьдралын туршлага, орчин, мэдрэх болоод сэтгэх чадвар гэхчлэн асар олон хүчин зүйлүүд нөлөөлөх магадлалтай тул нийтээр хүлээн зөвшөөрсөн үнэлэмж нь нийт үнэлэмжийг төлөөлөх боломжгүй гэж хэлж болно. Энд дурдагдсан "хэм хэмжээ"-г бас анзаарч үзмээр байна. Яагаад гэвэл үнэн хэрэг дээрээ хэм хэмжээ нь өөрөө үнэлэмж биш, харин **ҮНЭЛГЭЭНИЙ** хүсэх ба үл хүсэхүйн хязгаар юм гэж хэлж болно.

Судлаач Б.С.Ерасов 1998 онд Москвад хэвлүүлсэн "Нийгмийн соёл судлал" бүтээлдээ "Хэм хэмжээг мөрддөг үнэлэмж нь түүнээс ялгаатай нь илүү дээд оршихуй бүхий аль нэг объект, төлөв байдал, хэрэгцээ, зорилгын сонголт гэж ойлгогддог" /4. 114/ гэж санаагаа илэрхийлсэн байдаг. Үнэлэмж дан ганц эерэг байдаг бус, бас сөрөг үнэлэмж гэж буй. Энэ тодорхойлолтоос харахад хэм хэмжээг эерэг ба сөрөг үнэлэмжийн зааг гэж ойлгосон юм шиг сэтгэгдэл төрж байгаа юм.

А.А.Радугиний редакцитай 1997 онд Москвад хэвлэгдсэн "Соёл судлалын нэвтэрхий толь"-д "Үнэлэмж бол нийгмийн субъект (бодгаль, хүмүүсийн бүлэг, нийгэм)-ийн хэрэгцээ, хүсэл, ашиг сонирхлыг хангах нийгмийн аль нэгэн юмс, үзэгдлийн шинж юм" /12. 426/ гэсэн тодорхойлолт өгчээ. Тэгвэл үнэлэмжийг юмс, үзэгдлийн шинж хэмээн үзсэн нь түүнийг заавал объектод илүү хамааруулах гэсэн юм шиг сэтгэгдэл төрнө. Гэтэл

бусад олон тодорхойлолтонд үнэлэмжийг объектын шинж гэхээсээ дийлэнхдээ хэм хэмжээ, төсөөлөл, итгэл үнэмшил, утга, үнэлгээ, харилцаа, стандарт, чин эрмэлзлэл гэж субъекттэй илүү холбож юмуу, эсвэл дагнаж субъекттэй холбож тодорхойлсон байгааг анзаарахгүй өнгөрч болохгүй л болов уу. Үнэлэмжийг объектын шинж гэж үзэх юм бол энэ нь үнэлэмж бус, үнэний асуудал болж хувирах биз дээ.

Бид үнэлэмжийг юмс үзэгдлийн шинжээс огтхон ч хамааралгүй, угаасаа субъектив зүйл гэх гээд байна л даа. Энд субъектыг "нийгмийн" гэж тодотгосон нь ойлгогдохгүй байна. Учир нь "нийгмийн бус субъект" гэж хэлсэн юм болов уу гэж гайхана. "Хангах" гэж энд хэлсэн мөртлөө үргэлжлүүлээд "сайн, муу"-гийн төсөөлөл гэж оруулсан нь "муу" хэрэгцээ, хүсэл, ашиг сонирхлыг хангах гэсэн санаа болж ойлгогдож байна. Бас "нийгмийн ... юмс, үзэгдэл" гэсэн илэрхийлэл нь байгалийн болон санаалаг, тэрчлэн трансценденталь ертөнцийг зориуд гадна орхисон мэт сэтгэгдэл төрөхөөр байлаа. Энэ хуудсанд "материаллаг ба оюуны үнэлэмж" байдаг гэснийг материаллаг ба санаалаг ертөнцтэй холбогдох үнэлэмж байдгийг хэлснээс биш, материаллаг эд юмсыг үнэлэмж гэх юм уу, эсвэл оюун санаанаас ангид үнэлэмж байдаг гэж хэлээгүй байх хэмээн найдна.

Мөн К.М.Хорушенко 1997 онд Ростов на Дону хотод хэвлэн нийтлүүлсэн "Соёл судлал. Нэвтэрхий толь"-доо тодорхойлолт, тайлбар өгснийг дор толилуулья. Тэрээр "Үнэлэмж бол хүн, анги, бүлэг бүхэлдээ нийгмийн хувьд ариун зүйлийн тухай төсөөлөл, тэдгээрийн зан үйлд илрэх итгэл үнэмшил болон дээдлэл юм. Үнэлэмж нь бүх хүмүүсийн эталон, чин эрмэлзлэл болсон эргэлзээгүй зүйл байдаг. Тэдгээр нь нийгэм-улс төрийн ба оюуны, эерэг ба сөрөг байж болно" /10. 533/ гэх мэтээр бичжээ. Энд "ариун" гэхийн хамт сөрөг үнэлэмж байж болно гэжээ. Зохиогчийн яриад байгаа "ариун"-ыг бид сөрөг гэж үзнэ хэмээн яагаад ч бодож чадахгүй нээ. Нөгөө талаар үнэлэмж нь бүх хүмүүст адил эталон болсон байх нь эргэлзээтэйн зэрэгцээ, сөрөг үнэлэмж яагаад ч чин эрмэлзлэл болохгүй байх. Ер нь тэгээд "эргэлзээгүй" гэсэн илэрхийлэл нь ч эргэлзээтэй байхыг үгүйсгэхгүй. Энд "нийгэм-улс төрийн ба оюуны" гэж хослуулан нэрлэсэн нь хүртэл аспекти хувьд болхи сонголт болсон гэлтэй.

Бас нэгэн бүтээлээс иш татъя. В.И.Полищук 1999 онд гаргасан "Соёл судлал"-даа "...үнэлэмж бол хүнд ямар нэг утга холбогдолтой байж, түүний

ашиг сонирхлыг өдөөдөг юм болно. Тийм үнэлэмжийн ертөнц болон түүний үйлдвэрлэл бол соёл мөн” гээд:

**мэдрэхүй - хэрэгцээ - ашиг сонирхол - үнэлэмж - соёл**

гэсэн гинжин холбоог гаргаж тавьсан байна /8. 51/. Полищук гуайн дээрх санаанд үнэлэмж нь хүний ашиг сонирхлыг өдөөдөг гэсэн атлаа дараахи гинжин холбоонд ашиг сонирхол нь үнэлэмжийг өдөөдөг юм шиг дараалалд байрлажээ.

Эдгээр хэдхэн бүтээлийг аваад үзэхэд л байдал иймэрхүү байгаа юм. Тэгэхлээр аливаа эрдэм шинжилгээний бүтээл, сурах бичиг, гарын авлага, уншиж судлах материалд хянуур хандаж, шүүмжлэлтэй авч үзэж байх нь зүйтэй байна.

Зарим судлаачид үнэлэмжийн талаар “...ахуй гэдэг ойлголтын адил, цаашид яаж ч тодорхойлогдох боломжгүй ойлголтыг илэрхийлдэг энэ үгийг хэрэглэдэг...” гэсэн Г.Риккертийн үг, уг ойлголтын талаархи эмх замбараагүй байдлыг шүүмжлэн “Үнэлэмж нь манай шинжлэх ухааны урагшгүй хүүхэд болж байна” гэж М.Веберийн хэлсэн шүүмжлэл сэлтийг өлгөн авч, үнэлэмжийн тухай асуудал, улмаар соёлын тухай асуудлыг дур зоргоор ярьж, бичих “үнэлэмжгүй” талбар болгон ашиглах зорилго өвөрлөсөн байж болзошгүй гэдгийг ний нуугүй хэлэх хэрэгтэй юм.

Манайд үнэлэмжийн асуудлыг харьцангуй хожуу авч үзсэн байдаг хэдий ч олзуурхууштай нь тэд уг асуудлыг шаргуу судлан, цөөнгүй судлаачид уг асуудлаар эрдмийн зэрэг хамгаалж, зарим нь сурах бичиг, суралцагчдад зориулсан материал болон судалгаа, сурталчилгааны хэрэглэгдэхүүнд санаагаа илэрхийлсэн байх юм. Бид тэдгээрээс дараахи хэдэн докторын тодорхойлолтыг үлгэр болгож дурдъя:

Ц.Цэцэнбилэг-“Үнэлэмж бол хувь хүн өөртэйгөө адилтгадаг (харьцуулдаг) нийгэмлэгт болон өөрт нь ач холбогдол (утга) бүхий зан үйлийн эрхэмлэх зорилго хийгээд аргын тухай түүний төсөөллүүд юм” /1. 13/;

Ц.Гомбосүрэн-“Үнэлэмж бол тухайн субъектээс байгалийн юм уу нийгмийн тодорхой үзэгдэлд, бурхан тэнгэрлэгээр юм уу бурхан тэнгэрлэг бишээр төсөөлөгддөг ямар нэг далдлаг хүчинд өгч буй үнэлгээ мөн” /9. 307/;

Г.Чулуунбаатар-“Байгаль, нийгэм, хүний амьдралын үй түмэн үзэгдэлд сэтгэн үйлдэгч субъектийн зүгээс хандаж буй хандлага, үзэл бодол, үйл

ажиллагааны нийлбэр цогцсыг хамгийн ерөнхий байдлаар нь үнэлэмж хэмээх ойлголтоор илэрхийлж болно" /11. 16/;

Д.Мандах-"Үнэлэмж бол субъектийн оюуны үйлдлээр илэрдэг өвөрмөц маягийн харилцаа мөн" /7. 20/;

Ц.Баатартогтох-"Үнэлэмж бол тодорхой объектоор тэмдэглэн илэрхийлдэг, боловсруулан бүтээгдэж, түүнд субъектээс өгөгдсөн, иймээс зөвхөн түүнийг өвөр хоорондоо хэрэглэгчдэд ойлгомжтой байдаг субъектив утга юм" /1. 30/;

Л.Одонтуяа-"Үнэлэмж нь субъектийн оюуны үйл ажиллагаа мөн бөгөөд түүний хүсэл хийгээд үл хүсэхүйн утгыг илэрхийлэх үнэлгээ мөн" /7. 96/ гэж тус тус тодорхойлжээ. Эндээс "үйл ажиллагааны нийлбэр цогцсыг" л нэг эргэж харууштай юм шиг санагдсан. Бусад санаануудын хувьд "ирээдүйд" нэгдмэл санаа, нэг цэг дээр хүрэлцэн очихгүй гэх газаргүй биз ээ.

Эдгээр тодорхойлолтыг юуны түрүүнд судлаач, суралцагчдын эргэцүүлэлд хүртээмжтэй болгох зорилгоор энд толилуулан буйн зэрэгцээ нөгөө талаас философи, соёл судлалын төдийгүй хүмүүнлэгийн ухааны нийт салбарын нэн чухаг энэхүү ойлголтыг сонирхон тандагч хэн бүхэн тал бүрээс нь нухацтай авч үзээсэй хэмээн уриалах сэтгэлд автсанаа өчсүгэй. Мөхөс бидэн ч бас дараахи нэгэн санааг тодорхойлолт хэмээн үзэж томъёолох оролдлого хийсэнээ уншигч таны мэдэлд өргөн барья. Түшээд авна уу, түлхээд хаяна уу өөрөө мэдээрэй гэж манай ардын нэгэн дуунд өгүүлдэгсэн. Болгоон соёрхоно уу.

**Тэгэхээр үнэлэмж нь субъектээс аль нэг хэрэгцээгээ хангах үүднээс тухайн объектийг хүсэх юмуу үл хүсэх утга бүхий үнэлгээ мөн** гэж тодорхойлох саналтай байна. Өөрөөр хэлбэл энэ ойлголт нь субъектив агуулгаар дүүрэн юм /3. 69-70/.

Үнэлэмжийг зохистой зорилгын үүднээс үзэх онолын талынхан гэгдэх Ч.Эрбан, К.Льюис, Д.Прокл болон бусад төлөөлөгчид үнэлэмжийг зөвхөн ухамсрын үзэгдэл гээд энэ нь сэтгэлийн хөдлөл, үнэлж байгаа зүйлдээ хүнээс хандах субъектив харилцаа гэж үзсэн нь ч бий.

Үнэлэмжийн субъектив чанарын тухай доктор Ц.Баатартогтох зэрэг горилосон өөрийн бүтээлдээ чамлахааргүй хэдэн үндэслэгээг гаргаж тавьсан байдаг /1. 29/. Харин бид энэ асуудлаар цөөн санаа сэдэж байсан боловч



эмхэлж бүрдүүлэн энд тусгаж амжсангүй, хожмын өдөр бүрэн цэгцлээд олны хүртээл болгохоо амлая.

### Резюме

Автор в своей статье подтверждает, что не только в отечественной, но и в зарубежной философской литературе по вопросам теории ценности нередко встречаются непонятные выражения, логически противоречивые изложения.

Он также попытался дать свое определение философского понятия ценности на основе сравнительного анализа некоторых её определений, которые были сформулированы авторами разных стран.

### Ном зүй

1. Ц.Баатартогтох. Монголчуудын үнэлэмжийн судалгааны философийн асуудал. Докторын (PhD) зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. – УБ., 2000. – 112 т.
2. Т.Дорждагва. Соёлын философи (Түүхэн товчоон). – УБ.:ХИС-ийн хэвлэл, 2003. – 32 т.
3. Т.Дорждагва, Н.Сарантуяа, Г.Түмэннаст, Д.Эрдэнэбат. Харилцааны соёл. Онол, практик, судалгаа, үр дүн, зөвлөмж. – УБ.:МУИС-ийн Хэвлэх үйлдвэр, 2004. – 175 т.
4. Ерасов Б.С. Социальная культурология: Пособие для студентов ВУЗ-ов. – М.:Аспект Пресс, 1998. – 591 с.
5. Культурология (Конспект лекций). – Сост. А.А.Оганесян. – М.: "Изд-во ПРИОР", 2000. – 160 с.
6. Культурология: Учеб. для студ. тех. вузов / Колл.авт.; Под ред. Н.Г.Богдасаряна. -3-е изд., испр. и доп. – М.:Высш. шк., 2001. – 511 с.
7. Л.Одонтуйяа. Монгол зүйр цэцэн үгэнд үнэлэмж илрэх онцлог. Докторын (PhD) зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. – УБ., 2004. – 112 т.
8. Полищук В.И. Культурология: Уч. пособие. – М.:Гардарика, 1999. – 446 с.
9. Философи. Сурах бичиг. Ред:Ц.Гомбосүрэн, М.Отгонбаяр. – УБ.:МУИС-ийн Хэвлэх үйлдвэр, 2002. – 374 т.
10. Хорушенко К.М. Культурология. Энциклопедический словарь. – Ростов на Дону: "Феникс", 1997. – 640 с.

11. Г.Чулуунбаатар.Нийгмийн ардчилсан үнэлэмжийн тогтолцоо // Шинэ толь. – УБ., 1998. №23

12. Энциклопедический словарь до культурологии. Под общ. ред. А.А.Радугина. – М.:Центр, 1997. – 480 с.

13. Kluckhohn C., Strodtbeck F. Variation in Value orientation. - N.Y., 1961.